



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ардчилсан нам (АН)-ын Үндсэн
дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан нам (АН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Д.Батбаатарын танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Ариунболд, Д.Амарбаясгалан нараас “Үндэсний бодлогын хорооны нийт гишүүдийн 2/3-оос илүү тооны гишүүдийн санал гаргаснаар Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит 67 дугаар хуралдаанаар хэлэлцэн баталсан Ардчилсан намын Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгын нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” өргөдлийг 139 хуудас баримт, Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь)-ний хамт 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр ирүүлсэн баримтыг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ардчилсан нам (АН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасан.

Өргөдөл, түүнд холбогдох баримтуудаас үзвэл, Ардчилсан намын Ээлжит бус 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Их хурлын 15 дугаар тогтоолоор Ардчилсан намын хөтөлбөрийг, 16 дугаар тогтоолоор Ардчилсан намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг тус тус баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр өргөдөл гаргажээ.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Ардчилсан намын хөтөлбөр, Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх эсэх асуудлыг хэлэлцээд 53 дугаар тогтоолоор “намын дүрэмд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулсан, хуульд заасан асуудлыг дүрэмд өөрөөр зохицуулсан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй” үндэслэлээр, мөн бусад алдаа зөрчлийн талаар дурдаж, Ардчилсан намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хоёр. Энэхүү Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 53 дугаар тогтоолыг үндэслэн Ардчилсан намын дарга Б.Цогтгэрэлийн 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/009 дугаартай тушаалаар төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хорооны Ээлжит хуралдааныг 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр товлон зарлаж, тухайн намын цахим хуудсаар товыг мэдэгдсэн нь Ардчилсан намын Үндсэн дүрмийн (2022 оны) 5.13.10-д “ҮБХ-ны ээлжит хурлыг намын дарга, ҮБХ-ны дарга эсхүл УТЗ-өөс зарлана” гэсэнтэй нийцсэн байна.

Мөн дүрмийн 4.3.5-д “Хурлын ирц дараах байдлаар бүрдэнэ. Үүнд:”, 4.3.5.1-д “Бүх шатны намын байгууллагын хурлын хувьд Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхи”, 5.13.2-т “ҮБХ нь үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн мандатын тоог 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна. Үүнээс 76-аас доошгүй нь эмэгтэй, 76-аас доошгүй нь 39-өөс дээшгүй насны гишүүдэд ногдоно”, 5.13.3-т “ҮБХ-ны гишүүнийг тухайн аймаг, дүүрэгт ногдох УИХ-ын тойрог тус бүрийн хүрээнд нэр дэвшүүлж, харьяалагдах саналын эрх нь нээлттэй гишүүдээс сонгож, намын Их хурлаас батална” гэж заажээ.

Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хуралдсан Ээлжит 67 дугаар хуралдаанд 362 төлөөлөгчөөс 258 төлөөлөгч оролцож, ирц 71.2 хувь, эдгээрт залуучууд, чөлөөт, эмэгтэйчүүдийн насны ангиллын хувьд 39-өөс доош, 39-60, 60-аас дээш насны төлөөлөл багтсан, хурлын үйл ажиллагаанд 4 гишүүн ажиглагчаар оролцсон нь Үндэсний бодлогын хорооны гишүүдийн нэрсийн жагсаалт, гарын үсэг бүхий ирцийн бүртгэл, хурлын тэмдэглэл, Үндэсний бодлогын хорооны хуралдааны бүрэн эрхийг баталсан 30 дугаар тогтоол, фото зураг (нийтэд илэрхий) болон бусад баримтаар тогтоогдож байх тул тухайн хурлын процесс зөрчилгүй байна.

Гурав. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг

хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж;

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 4.1-д “Бүх шатны намын байгууллага, гишүүд аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ олонхоороо шийдвэр гарган, цөөнхийн саналыг хүндэтгэлтэй сонсон хуралдааны тэмдэглэлд тусгаж, нийтээрээ даган мөрдөх нэгдмэл зарчмыг баримтална”, 4.3.4-т “Аливаа сонгуультай холбоотой намын гишүүний асуудлыг өрсөлдөгчгүй тохиолдол биш бол нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах эсвэл санал нэгдэх замаар шийдвэрлэнэ, 4.4-т “Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ”, 4.5-д “Бусад тохиолдолд хурлын шийдвэр нь Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол хуралд оролцогчдын ердийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно” гэж тус тус заасан.

Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Ээлжит 67 дугаар хуралдаанаар Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгын нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж, 258 төлөөлөгч хуралдаанд оролцсоноос дэмжсэн 96 хувь, дэмжээгүй 4 хувийн саналыг өгсөн болох нь хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар тогтоол, холбогдох бусад баримтаар тогтоогдож байна.

Үндэсний бодлогын хорооны Ээлжит 67 дугаар хуралдаанаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 53 дугаар тогтоолын үндэслэлд дурдсан “хяналтын байгууллагын түдгэлзүүлэх шийтгэлийг ямар хугацаатай ногдуулах, сахилгын шийтгэл ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа, гүйцэтгэх байгууллагын бүрэлдэхүүнийг нөхөн сонгох зохицуулалт, намын даргыг чөлөөлөх, огцруулах шийдвэрийг намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагын аль нь гаргах эрхтэй болох, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар бүтцийн нэгжид хуваарилахтай холбоотой асуудал, төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнд орон гарсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг нөхөн батламжлах эрхийг төлөөллийн төв байгууллага өөртөө олгосон нь буруу болохыг, санхүүгийн тайлан болон хориглосон этгээдээс хандивт авснаас үүссэн алдаа зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Жендерийн бодлогын баримт бичгийн журам батлах бүтцийн байгууллагын чиг үүргийн давхцал болон техникийн шинжтэй алдаа зөрчил”-ийг засаж, хуульд нийцүүлэн Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Харин тус хуралдаанаар Улсын дээд шүүхийн тогтоолд дурдаагүй, тус намын 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус Их хурлаас баталсан Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийн 75.3-т заасан Үндэсний бодлогын хорооны бүрэлдэхүүний тоог нэмсэн өөрчлөлт оруулсныг бүртгэх боломжгүй. Тодруулбал;

Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын хавсралтаар намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийн 75.3 дахь заалтыг “ҮБХ нь таван зуун тавин таван (555) гишүүнээс бүрдэнэ. Үүний таван зуун дөрөв (504) нь УИХ-ын нэг зуун хорин зургаан (126) гишүүний тоог дөрөв (4)-өөр үржүүлсэнтэй тэнцүү байх ... Нэмэлтээр тавин нэгэн (51) гишүүнийг намын

даргын санал оруулснаар намын Их хурлаар батламжилна.” гэж өөрчилсөн нь намын удирдах дээд байгууллагад хуулиар хадгалагддаг онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлж буюу Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

Үндэсний бодлогын хорооны бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлсэнтэй холбогдуулан аймаг, дүүргийн намын хорооны хурлаас сонгогдох ҮБХ-ны гишүүний тоог өөрчилсөн, 75.5.1 дэх заалтын “ҮБХ-ны таван зуун дөрвөн (504) суудлаас эмэгтэй гишүүдэд хоёр зуун хоёр (202) ...”, 75.5.1.1 дэх заалтын “аймаг, дүүрэг тус бүрд ногдох эмэгтэй гишүүдийн тавин (50) суудал нь ...”, 75.5.1.2 дахь заалтын “эмэгтэй гишүүдийн суудлаас үлдсэн нэг зуун тавин хоёр (152) суудлыг аймаг, дүүрэг тус бүрд ҮД-ийн 75.7-д заасны дагуу хуваарилна”, 75.5.2 дахь заалтын “ҮБХ-ны нийт гишүүдийн таван зуун дөрвөн (504) суудлаас эмэгтэй гишүүдийн хоёр зуун хоёр (202) суудлыг хасаж, үлдсэн гурван зуун хоёр (302) суудлыг ...”, 75.5.2.2 дахь заалтын “чөлөөт гишүүдийн суудлаас үлдсэн хоёр зуун далан хоёр (272) суудлыг аймаг, дүүрэг тус бүрд ҮД-ийн 75.7-д заасны дагуу хуваарилна”, 75.7 дахь заалтын хүснэгтэн мэдээлэл зэргийг мөн бүртгэх боломжгүй.

Харин, Ардчилсан намын 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус Их хурлын 16 дугаар тогтоолоор баталсан Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийн 75.3 буюу “ҮБХ нь УИХ-ын нэг зуун хорин зургаан (126) гишүүний тоог гурав (3)-аар үржүүлсэнтэй тэнцүү буюу гурван зуун далан найман (378) гишүүнтэй байх ...”, 75.5.1 буюу “ҮБХ-ны нийт гишүүдийн гурван зуун далан найман (378) суудлаас эмэгтэй гишүүдэд нэг зуун тавин хоёр (152) суудал ногдох бөгөөд дараах байдлаар хуваарилна. Үүнээс:”, 75.5.1.1 буюу “аймаг, дүүрэг тус бүрд ногдох эмэгтэй гишүүдийн суудлын нэг (1) суудал нь гучин ес (39)-өөс дээшгүй насны эмэгтэй гишүүдэд ногдоно”, 75.5.1.2 буюу “эмэгтэй гишүүдийн суудлаас үлдсэн нэг зуун хорин хоёр (122) суудлыг аймаг, дүүрэг тус бүрд хуваарилна”, 75.5.2 буюу “ҮБХ-ны нийт гишүүдийн гурван зуун далан найман (378) суудлаас эмэгтэй гишүүдийн зуун тавин хоёр (152) суудлыг хасаж, үлдсэн хоёр зуун хорин зургаан (226) суудлыг чөлөөт суудал гэх бөгөөд дараах байдлаар хуваарилна. Үүнээс:”, 75.5.2.2 буюу “чөлөөт гишүүдийн суудлаас үлдсэн зуун ерэн зургаан (196) суудлыг аймаг, дүүрэг тус бүрд хуваарилна”, 75.7 буюу “АН-ын ҮБХ-ны гишүүний суудлын хуваар”-ийг харуулсан хүснэгтэн мэдээллээр нь бүртгэх нь зүйтэй байна.

Иймээс Ардчилсан нам (АН)-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/215 дугаартай албан бичгээр ирүүлсэн “... дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх явцад гишүүдээс (заалнаас) дүрмийн 75.5 дахь заалт болон түүнтэй холбоотой бусад заалтыг өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасан нь олонхын санал авснаар дэмжигдсэн, ... бусад өөрчлөлтийн хамт нийлээд намын дүрмийн гуравны нэгээс хэтрээгүй, ... Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасны дагуу намын төлөөллийн төв байгууллагаас намын дүрэмд өөрчлөлт оруулах санал гаргах, өөрчлөх нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар тогтоогдсон алдаа, зөрчлөөр үл хязгаарлагдана, ... Үндсэн дүрмийн 75.5 хэсэгт ба холбогдох бусад заалтыг өөрчилсөн нь намын удирдах дээд байгууллага болох намын Их хурлын бүрэн эрхэд халдаагүй ...” гэсэн тайлбарыг шүүх хүлээн аваагүй болно.

Дөрөв. Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын хавсралтаар намын Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгын нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа дүрмийн 18.1.8-18.1.19-д заасан сахилгын зөрчилд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсан. Энэ талаар Ардчилсан нам (АН)-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/205 дугаартай албан бичгээр "... Үндсэн дүрмийн 18.2.1 дэх заалтыг өөрчлөн найруулж, уг заалт доторх 18.1.2 болон 18.1.4 гэсэн зөрчилд оногдох шийтгэлийг тусад нь тодорхойлж нэмэхдээ өмнө байсан 18.2.2."ҮД-ийн 18.1.2, 18.1.4-д заасан зөрчилд тухайн сонгуульт албанаас чөлөөлж, намын дотоод сонгуульд нэр дэвших эрхийг тухайн бүрэн эрхийн хугацаагаар түдгэлзүүлэх" гэсэн заалтыг дарж редакцын алдаа гаргасан байгааг залруулж байна. Ингэснээр энэхүү орхигдсон заалт 18.2.3 болж орох бөгөөд арын заалтуудын дугаарлалтууд мөн нэг дугаараар хойшилж засагдахаар байна, ...тус хуралдаанаас гаргасан ҮБХ-ны 32-33, 35-38 дугаар тогтоолуудад үндэслэсэн "Тооллогын комиссын 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 31 дүгээр тогтоол" гэдэгт мөн редакцийн алдаа гарсан байх бөгөөд "Тооллогын комисс байгуулах тухай Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 31 дүгээр тогтоол" гэж залруулж байна ..." гэсэн тайлбарыг ирүүлсэн байх тул тухайн заалтыг зөрчилгүй, засагдах боломжтой гэж үзлээ.

Тав. Ардчилсан намын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Ээлжит бус Их хурлаар Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг батлахдаа намын бэлгэдэл, далбаанд өөрчлөлт оруулсан, энэ талаар тус намын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 02/211 дугаартай албан бичгээр "Дүрмийн төсөл боловсруулах ажлын хүрээнд "намын туг" гэсэн нэршлийг хуульд тусгагдсаны дагуу "намын далбаа" болгон өөрчилж, улмаар далбааны улаан, хөх, цагаан өнгөний харьцаанд жижиг завсар оруулснаар 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хуралдсан намын Их хурлаар баталсан, ... намын далбааны ерөнхий харьцаа, өнгөний код, өнгөний хослол, дүрсийн ерөнхий шийдэлд өөрчлөлт ороогүй болно. ... тугны загвар сонгон шалгаруулах нээлттэй уралдаан зарласан, уг загварыг ирүүлсэн уран бүтээлч Д.Цогтбаярт шагналыг гардуулснаар намын өмчлөлд шилжсэн, өнөөдрийг хүртэл 33 жил үйл ажиллагаандаа тасралтгүй ашиглаж, Ардчилсан намын биет бус хөрөнгө болгон өмчилж ирсэн" гэх агуулга бүхий тайлбар ирүүлснийг дурдав.

Өмнөх, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 53 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзсан Ардчилсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга) нь нийт 1524 буюу 20 бүлэг, 160 зүйл, 645 хэсэг, 667 заалт, 32 дэд заалттай байсан.

Үндэсний бодлогын хорооноос Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгын нэмэлт өөрчлөлт оруулахдаа дээрх дүрмийн нийт 48 буюу 21 хэсэг, 20 заалт, 7 дэд заалт, техникийн шинжтэй 139 заалттай нэмж тооцоход дүрмийнх нь 12.27 хувьд нэмэлт, өөрчлөлт оруулсан гэж үзэхээр байна.

Дээрх нөхцөл байдлыг дүгнээд, Ардчилсан нам (АН)-ын 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус Их хурлын 16 дугаар тогтоолоор баталсан Ардчилсан намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга), түүнд нэмэлт, өөрчлөлт

оруулсан Үндэсний бодлогын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоол, уг тогтоолын хавсралтын Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны бүрэлдэхүүний тоог өөрчилснөөс бусад нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан тул дээр дурдсан намын Их хурлын 16 дугаар тогтоолоор баталсан Үндэсний бодлогын хорооны бүрэлдэхүүний тоотой холбоотой заалтын хамт тус намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүхэлд нь бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Ардчилсан нам (АН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР